

6

**МАКРО ЭДИЙН ЗАСАГЧ БОЛ ЭРДЭМТЭН
ХИЙГЭЭД ИНЖЕНЕР МӨН (Орчуулга)**

Д.Хишгээ, Р.Батжаргал

Гарвардын их сургуулийн профессор Н.Г.Мэнкью.

Эдийн засагчид өөрсдийгөө эрдэмтэн судлаач хэмээн нэрлэх дуртай. Би үүнийг үнэн хэрэг дээрээ тийм болохыг баталж чадах юмаа. Лекц уншихдаа хичээлийн эхэнд нэг ч оюутанг өдөр тутмын ямар нэг үйлд оролцож байна гэж бодуулахгүйн тулд эдийн засгийн онолыг шинжлэх ухаан болохыг ойлгуулан хатуу анхааруулдаг билээ. Физикийн факультетын багш нарт та бид нар чинь номын ойрын хамаатан садан юм шүү дээ гэхэд их гайхдагсан. Ер нь эдийн засагчид өөрийн онолыг хувь хүний үйл хөдлөлтэй холбоотой их хэмжээний мэдээлэл цуглуулан, математикийн аппарат ашиглан нарийвчлал сайтай тодорхойлж чаддаг байна. Тэгэхдээ статистикийн маш нарийн технологи ашиглан туршлага дээр үндэслэн шүүн хэлэлцэж байж урьдчилсан таамаглал, дүгнэлт гаргаж байдаг юм.

Вашингтонд эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөхөөр хоёр жил ажиллахдаа макро эдийн засаг анхлан бүрэлдэн тогтохдоо шинжлэх ухааны мэдлэг дээр бус харин юунаас ч илүүтэйгээр инженерийн янз бүрийн шийдэл байсан юм биш үү гэж санагдах болсон билээ. Бурхан бидэнд янз бүрийн гоёмсөг онолыг дэвшүүлэх, түүнийг шалгахыг бус харин түвэгтэй практик асуудлыг шийдэхийн тулд эдийн засгийг даатган өгсөн билээ. Манай шинжлэх ухааны шинэ аргыг өргөн хүрээ хамарсан 1930 -аад оны - Их хямрал төрүүлсэн юм. Өчүүхэн бага орлого, газар сайгүй бий болсон ажилгүйдэл капиталист систем амьдрах чадвартай юу ? гэсэн асуудлыг бодитойгоор хөндсөн юм.

Энэ өгүүллэгт макро эдийн засгийн түүхийг товчлон хүргэхийн хамт бид юунд суралцаж, ямар туршлага хуримтлуулж амжсанд дүгнэлт өгөхийг зорив. Манай шинжлэх ухааны хөгжил хоёр өөр урсгалын макро эдийн засагчдын хүчин чармайлтаар бий болсон гэж би бодож байна. Энэ нь: нэг нь инженерийн төрөл гэж ойлгодог, нөгөө нь цэвэр шинжлэх ухаан гэж үздэгт оршино. Инженерүүд гэдэг бол - юуны өмнө аль нэгэн тодорхой асуудлыг шийдэж байдаг хүмүүс. Эрдэмтдийн зорилго бол - дэлхий ертөнцийн зүй тогтлыг ойлгон тайлбарлах явдал билээ. Макро эдийн засагчид дээрх хоёр хандлагыг ээлжлэн баримталж ирснийг эдийн засгийн хөгжлийн түүх харуулж байна. Үнэхээр анхны үе шатныхан нь практик асуудлыг шийдэхийг оролдож байсан бол дараагийн үеийн судлаачид нь аналитик аргыг хөгжүүлэх, мөн онолын зарчмуудыг боловсруулахыг сонирхох болсон. Гэвч энэхүү онолын зарчим, арга хэрэгслийг бодитойгоор шуудхан хэрэглэж чадаагүй юм. Эдийн засгийн шинжлэх ухааны эрчимтэй хөгжихийн хирээр “эрдэмтэд”, “инженерүүдийн” хоорондын харилцаа тийм ч таатай сайн байсангүй. Тэдний үзэл санааны хооронд ноцтой ялгаа бодитой оршин байдаг нь бүх макро эдийн засагчдын хувьд сэтгэлийн том дарамт болж байдаг билээ.

Шууд утгаар ойлгохоос сэрэмжлэхийн тулд энд өгүүлэх гэж буй түүх бол “сайн, муу залуусын” тухай биш гэдгийг зориуд анхааруулъя. Эрдэмтэн нь ч тэр инженер нь ч тэр эдийн засгийн онолын хөгжилд гол үүрэгтэй байх хэмээн өрсөлдөөгүй юм шүү. Суут сэтгэгч ба энгийн үүрэг гүйцэтгэгчийг зэрэгцүүлэн ярьж болохгүй биздээ. Инженерийн ямар нэгэн асуудлыг шийдэх гэсэн эрдэмтэн эр, шинжлэх ухааны зорилгыг шийдэх гэсэн инженерээс огтхон ч ялгаагүй. Энэ хоёр тохиолдолд онолын хувьд ч, практик хувьд ч тодорхойгүй байдал үүсэж байна. Нийгэмд уг хоёр сургаалийг баримтлагч макро эдийн засагч нар байнга хэрэгцээтэй байсаар байна. Хамгийн гол нь эдийн засагч нар маань макро эдийн засгийг танин мэдэх гэсэн дээрх хоёр хэлбэр ийнхүү оршин байгааг ямагт санаж байх болбоос эдийн засгийн онол улам эрэмбэ дараалалтай, илүү үр дүнтэй хөгжихсөн гэдэгт би итгэж байна.

Кейнсийн хувьсгал

Макро эдийн засаг гэсэн нэр томъёог анх онолын ном зохиолд 1940-өөд оноос хэрэглэх болсон байна. Эдийн засагчид инфляц, ажилгүйдэл, эдийн засгийн өсөлт, эдийн засгийн мөчлөг, мөнгөний ба фискал бодлого зэрэг асуудлуудыг мэдээж эртнээс анхааран сонирхож байсан ажээ. Тэртээ ХҮШ зуунд Д.Юм валютын довтолгооны богино ба удаан хугацааны үр дүнгийн талаар бичиж байсан бөгөөд түүний хийсэн олон судалгаа нь орчин үеийн мөнгөний эдийн засагчид эсвэл төв банкны ажилтан нарын санал боловсруулахтай яг адил байв. Хэдий тийм боловч макро эдийн засгийн тодорхой салбарын судалгаа Их хямралын үед үүсчээ. Учир нь оюун ухаан дайчлахад хямралаас илүү хэрэгсэл байгаагүй юм.

1933 онд АНУ-д ажилгүйдлийн түвшин 25%-д хүрч бодит ДНБ-ний хэмжээ 1929 оныхоос 31%-иас доош болж буурсан байв. АНУ-ын эдийн засагт тохиосон дараа дараагийн хямрал нь энэ цунамитай харьцуулахад амгалан

нууранд долгилох жижиг давалгаа л гэсэн үг. Тэр үеийн нэртэй эдийн засагчид болох Л.Клейн, Ф.Модильяни, П.Самуэльсон, Р.Солоу, Ж.Тобин нарын өөрсдийн тухай бичсэн түүхэн эссэнээс уншихад хямрал бол тэднийг мэргэжлээр өсөх гол нөхцөл болсон гэж санал нэгтэй тодорхойлсон байна.

Энэ үзэгдлийг хэрхэн ойлгох хэлэлцүүлэг маргааны гол цэг нь Ж.Кейнсийн “Ажил эрхлэлт, хүү, мөнгөний ерөнхий онол” бүтээл болов. Гарвардын их сургуульд 1930 оны сүүлч 1940 оны эхээр суралцаж байхдаа энэ номыг анх хэвлэгдэн гарч ирэхэд энэ бүтээлийг хуучин багш нар ихэвчлэн дайсагнан хандаж, ялгаварлан гадуурхаж байхад залуу багш, аспирантууд дуу алдан хүлээн авч байлаа гэж Тобин дурссан байдаг. Залуучууд ахмад үеэс шинийг хүлээн авах чадвар ямагт сайн бөгөөд хурдан өөрчлөгдөж байдгийн жишээ байх л даа. 1930 оны эдийн засгийн сэтгүүлүүд дээр Кейнс, Маршалл нар эн цацуу иш татагдаж байв. Харин 1940 оны үед тэрээр Хиксийн дараа хоёрдугаарт бичигдэж байсан бөгөөд олон жилийн дараа 1966-1986 онд иш таталтын индексээр Кейнс 14 дүгээр хүндэт байранд жагсаж байжээ. Кейнсийн онол зөвхөн эдийн засгийн судалгаа шинжилгээнд төдийгүй эдийн засгийн онолыг судлахад хувьсгал хийлээ. 1948 онд Самуэльсоны “сонгодог-шилдэг” сурах бичиг хэвлэгдэн гарлаа. Номын бүтэц хийгээд логик санаа нь зохиогч кейнсийн сургаалийг баримтлагч болохыг харуулж байв. Эдийн засгийн онолд орсон өнөөдрийн тулгуур ойлголтын хэсэг болох эрэлт, нийлүүлэлтийн тухай зөвхөн 447 ба 608 дугаар хуудсанд цухас дурьдсан байжээ. Номын эхэнд хадгаламжийн парадокс ба татварын үржүүлэгчийн тухай дурьдсан байлаа. Орчин цагийн эдийн засагч нарт “. . . ерөнхий онол”-ыг уншиж ойлгоход тэдний хувийн туршлага нь туслах боловч бас эргээд саад болдог гэж үзэж байдаг. Нэг талаас энэ бүтээл хамрах хүрээний хувьд ямарч эргэлзээгүй нийгмийн том асуудлыг хөндсөн байдаг. Нөгөө талаас тус номонд маш тодорхой шинжилгээ хийсэн байдаг боловч олон тайлагдаагүй зангилаа, асуудал үлдсэн явдал болно. Уншигч: номонд гарч байгаа саланги хэсгийг хооронд нь холбогч ямар нэг нэгдмэл тодорхой эдийн засгийн загвар гарч ирэх нь гэж хүлээсээр уншиж дуусдаг. Удалгүй “. . . ерөнхий онол”-ыг хэвлэгдсэний дараа макро эдийн засагчид Кейнсийн үзэл санааг илэрхийлсэн илүү хялбар тодорхой загварыг бүтээж эхэлсэн билээ. Анхдагч үр дүнтэй загварт 33 настай Хиксийн бүтээсэн IS-LM загварыг нэрлэж болох юм. Дараа нь 26 настай Ф.Модильяни түүнийг цаашид өргөтгөн илүү тодорхой болгон тайлбарлав. IS-LM загвар өнөөдрийг хүртэл макро эдийн засгийн хамгийн шилдэг сурах бичигт ороод тодорхой хүрээнд ашиглагдаж байна. Эдийн засгийн онолчид /Хикс ба Модильяни нар / кейнсийн загварыг хөгжүүлэн их сургуульд заахад тохиромжтой хэлбэрт хүргэж, тэрчлэн статистикч нар /жишээ нь Клейн / эдийн засгийн бодлого боловсруулахад хэрэглэж болох тоо баримт хавсаргасан илүү сайн загварыг боловсруулжээ. Цаг хугацааны туршид энэ загвар боловсрон хөгжсөөр эцэстээ хэдэн зуун хувьсагч бүхий тэгшитгэл болон хувирсан байна.

1960 он гэхэд аль нэг нэр алдартай кейнсчийн үзэл санаан дээр тулгуурласан хоорондоо өрсөлдөн бүхий хэдэн загвар бий болсон байв. Уортоны загвар Клейны онол дээр тулгуурласан бол DRI загвар О.Экштгейны үзэл бодол

дээр үндэслэсэн, MPS загвар А.Андо болон Модильянийн ажлын үр дүн байх жишээтэй. Энэ загваруудыг улс төр- эдийн засгийн бодлогыг төлөвлөх, боловсруулахад өргөн ашиглаж байна. АНУ-ын Холбооны Төв банк олон жил MPS загварыг дэмжиж ирсэн бөгөөд америкийн засгийн газрын одоо ч ашиглаж байгаа FRB/US загварын өмнөх хувилбар юм.

Загварууд зөвхөн багахан хэсгээрээ ялгаатай болохоос бүтцийн хувьд бүгд кейнсийнх байдаг. Тэдгээрийг бүтээсэн, тухайн загварыг дэмжигч нар өнөөдөр ч оюутнуудад түүнийгээ заасаар байна. IS муруй улс орны санхүүгийн байдал ба татварын бодлогын ДНБ-тэй харьцах харьцааг илэрхийлнэ. Харин LM муруй нь мөнгөний эрэлт нийлүүлэлтийн тэнцвэржүүлэх үнэ болох зээлийн хүүгийн түвшинг тодорхойлно. Харин Филлипсийн муруй нь цаг хугацааны явцад эдийн засгийн өөрчлөлтийг харуулах бөгөөд энэ нь үнийн түвшний өөрчлөлтөнд илэрнэ. Шинжлэх ухааны ертөнцөд "... ерөнхий онол" үнэхээр том нээлт болжээ. Тухайн үеийн шилдэг залуу оюун ухааныг кейнсийн хувьсгал үнэхээр сэрээж амьдруулсан гэж үзэж болно. Түүний ачаар богино хугацаанд эдийн засаг хэрхэн өөрчлөгдөх талаар шинэ ойлголт гарч ирлээ. Самуэльсоны тодорхойлсноор Кейнсийн хувьсгал бол ХХ зууны эдийн засгийн онолд гарсан хамгийн агуу үйл явдал мөн. Түүний үеийн олон эдийн засагч энэ саналыг хуваалцаж байдаг юм.

Гэхдээ Кейнсийн хувьсгалыг цэвэр шинжлэх ухааны хөгжлийн нэг үе шат гэж үзэж болохгүй. Эл загварыг зохиогч Кейнс өөрөө болон түүний загварыг сайжруулагчид бол маш авьяаслаг инженерүүд байлаа. Онолын үндэслэл нь бодит амьдралаас урган гарсан учраас тэд онолоо боловсруулж амьдралд хэрэгжүүлэхийг эрмэлзэж байв. 1946 онд нас барах хүртлээ Кейнс улс төрийн зөвлөхөөр ажиллаж байсан ба 1960 онуудад Тобин, Солоу, Экштейн нар Эдийн засгийн хороонд зөвлөхөөр ажиллахын тулд эрдэм шинжилгээний судалгаагаа орхиж байжээ. 1964 онд хэрэгжүүлсэн татварыг бууруулах талаар баримталсан Ж.Кеннедийн бодлого нь кейнсийн парадигм ба түүний загваруудын үйлчлэлийн олон тооны үр дүн түүнийг зоригжуулсан явдал байв.

Шинэ сонгодог онолчид

1960 оны төгсгөлөөс кейнсийн онол дээр тулгуурласан эдийн засгийн нэгдмэл онол ганхаж эхлэв. Тухайн үед үнэн зөв нь эргэлзээгүй мэт байсан эдийн засгийн загварууд эцсийн эцэст нуран уналаа: ингээд сонгодог хэлбэрийн өөр төсөөлөл төрөн гарч ирэв. Шинэ сонгодог онолын хөгжлийн эхний үе шатны үзэл бодлын хамгийн гарамгай илэрхийлэлд М.Фридмены мөнгөний интерпретаци зүй ёсоор хамаарагдана. Тухайлбал Фридмен фискаль бодлогын олон хувьсагч дээр үндэслэсэн кейнсийн хэрэглэгээний функцийг шүүмжилсэн нь үнэндээ Кейнсийн төрийн зохицуулалтын онолыг давхар шүүмжилсэн хэрэг байлаа. Хугацаанаас хамааралтай орлогын ахиу хэрэглэх хандлага бага байвал татварын бодлогын тэнцвэрт орлогод нөлөөлөх нөлөө нь мэдэгдэхүйц бага байна гэж М.Фридмен тодорхойлсон нь кейнсийн онолын эсрэг үзэл санааг бий болгожээ.

"АНУ-ын мөнгөний бодлогын түүх" номонд М.Фридмен, А.Шварц хоёр ажил хэрэгч мөчлөгийн асуудлыг шууд хөндөж ингэснээр кейнсийн парадигмыг

шүүмжлэв. Дийлэнх кейнсчүүд эдийн засгийг байгалийн мөн чанараар тогтворгүй орчин, хөрөнгө оруулагчдын "амьд байх зөн совин", "амьдралыг амтлах" гэсэн хүслийн хооронд хэлбэлзэж байдаг гэж үзэж байсан. Харин Фридмен, Шварц нар ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРГҮЙ БАЙДЛЫН ШАЛТГААН НЬ макро бодлого бүхэлдээ муу байгаатай холбоотой бөгөөд аль нэгэн эдийн засгийн агентлагуудын алдаатай үйл ажиллагаатай холбоогүй гэж үзсэн юм. Шийдвэр гаргаж байгаа улс төрийн бодлого нь энгийн дүрэм журамтай байх бөгөөд эдийн засгийн үйл явцад хутгалдан орж гай болоогүйд нь талархах ёстой ажээ. Хэдийгээр Фридмены санал болгосон тогтвортой өсөлтийн дүрэм өнөөдөр төдийлэн олон дэмжигч байхгүй боловч олон улс орны Төв банкны инфляцийг тогтворжуулахад чиглэсэн бодлогын үндэс суурь нь болж байдаг.

1968 онд Америкийн эдийн засагчдийн холбоонд ерөнхийлөгчөөс хандсан илгээлтэнд Фридмен, Фелпсийн хамт кейнсийн онолын эмзэг хэсэг болох Филлипсийн муруйн хүрэн дэх ажилгүйдэл, инфляцын хоорондын зохицолгоо, хамаарлын асуудлыг шүүмжилсэн байдаг. Хэдийгээр Кейнс өөрөө гаргаж ирээгүй боловч Самуэльсон, Солоу хоёроос эхлэн хөгжүүлсэн Филлипсийн муруй кейнсийн парадигмын үндсэн элемент болсон байлаа. Дээрх зохицолгоо хийгээд хамаарал маш түвэгтэй болохыг Самуэльсон, Солоу нар ойлгож байсан бөгөөд тэдний бүтээлд энэ талаар маш олон сануулга, тайлбар өгсөн байх бөгөөд урт ба богино хугацаанд энэ хамаарал Филлипсийн муруйд ялгаатай тусгагдана гэж үзсэн. Кейнсийн загварт үнэ яагаад зах зээлийг тэнцвэржүүлж чадахгүй байгааг, үнийн түвшин цаг хугацааны явцад хэрхэн тэнцвэржиж болдог тухай тайлбарлах нь байнга хүндрэлтэй байсан учраас Филлипсийн муруй кейнсийн загварыг эвтэйхэн тайлбарлаж дуусгах боломжийг олгож байжээ.

Хэрвээ сонгодог зарчим үнэн байгаад мөнгө нейтраль гэж үзэх юм бол удаан хугацааны туршид ажилгүйдэл ба инфляцын хооронд альтернатив чанар хадгалагдахгүй гэж Фридмен нотлож байв. Богино хугацаанд инфляц хүлээгдээгүй байдаг учраас ажилгүйдлийг бууруулах боломжтой. Энэ гайхалтай үзэгдлийг тайлбарлах тусгай механизмийг Фридмен ажилчдын мөнгөний хий үзэгдэл /хүлээлт/ -ээр тайлбарласан. Энэ санаа маш чухал байсан бөгөөд Фридмены энэ онолын ачаар макро эдийн засагт хүлээлтийн тухай ойлголт бий болж энэ нь цаашид эдийн засгийн онолд чухал үүрэг гүйцэтгэх болсон байна.

Дээр өгүүлсэн бүхэн нь рациональ хүлээлтийн онолтой холбоотой төрөн гарч ирсэн шинэ сонгодог эдийн засагчдийн хоёрдугаар үе хөгжих шимтэй хөрс болж өгөв. Фридмений санааг хөгжүүлэн Р.Лукас Кейнсийн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн загварыг эдийн засгийн бодлогод ашиглаж болохгүй, учир нь тэрээр хүлээлтийг тооцоолоогүй: иймээс энэ загвараар улстөр, эдийн засгийн шинэ бодлого хэрэгжүүлж байгаа үед, тэр загварыг бодит туршлагын тоо баримтууд дээр үндэслэн үнэлгээнүүдийг харьцуулан жиших юм бол ямарч үр дүн байхгүй болно хэмээн сануулжээ. Лукас бүрэн бус мэдээлэл бүхий нөхцөл дахь рациональ хүлээлт, зах зээлийн тэнцвэржилтэнд үндэслэсэн ажил хэрэгч мөчлөгийн онолыг дэвшүүлэн тавилаа. Лукасын энэ онолоор харьцангуй үнийн динамикийг зохицуулах боломжгүй ба агентлагуудын хувьд үнэ хүлээгдээгүй

байгаа зөвхөн энэ тохиолдолд мөнгөний онол ач холбогдолтой гэж үзсэн. Р.Бэрроу энэ загвар нь америкийн баримт жишээнд тохирч байна гэж баталгаажуулав. Т.Саржент, Н.Уоллес нар энэ онол дээр үндэслэсэн эдийн засгийн бодлогыг ашигласны үр дагаварыг тодорхойлохдоо : гэнэтийн шокийг үргэлж тооцоолох боломжгүй учраас эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн мөнгөний системтэй бодлого дампуурах болно гэж сануулав.

Шинэ сонгодог эдийн засгийн онолын хөгжлийн гуравдугаар үе Кюдланд-Прескотта ба Лонга-Плоссер нарын бодит ажил хэрэгч мөчлөгийн загварт тусгалаа олжээ. Фридмен, Лукас нарын онолд тусгагдсаны адил дээрх загварт үнэ нь аливаа өөрчлөлтөнд дагаж зохицож улмаар зах зээлийг тэнцвэржүүлнэ гэж үзжээ. Энэ үзэл санаа нь шинэ сонгодогчууд Кейнсийн онолоос эрс татгалзсаны илэрхийлэл байлаа. Гуравдугаар үеийн шинэ сонгодогчуудын анхны онолоос ялгагдах онцлог нь бодит ажил хэрэгч мөчлөгийн онолоор эдийн засгийн хэлбэлзэлийг тайлбарлахдаа мөнгөний бодлого хүлээгдэж байгаа эсэхээс үл хамаарна гээд мөнгөний бодлогын ач холбогдлыг эрс бууруулсан явдал юм. Онолын гол санаа нь гэнэтийн технологийн шок, түүнээс үүдэлтэй түр хугацааны хэрэглэгээний чиглэл, чөлөөт /ирээдүй цаг / цаг уруу анхаарлыг хандуулсанд оршино.

Шинэ сонгодог парадигмын хөгжлийн үр дүнд макро эдийн засаг нь микро эдийн засгаас илүү их хамааралтай хатуу дэгтэй шинжлэх ухаан болов. Бодит ажил хэрэгч мөчлөгийн загвар нь Эрроу-Дебрегийн ерөнхий тэнцвэрийн онолын онцгой нэг төрөл юм. Нилээд хугацааны турш энэ талыг баримтлагчид ажил хэрэгч мөчлөг нь мөнгөний хүчин зүйлээр биш харин бодит хүчин зүйлээр зохицуулагдана гэж үзэж байв. Өнөөдөр шинэ сонгодог онолоор хүмүүжсэн олон макро эдийн засагч нар эдийн засгийн субъектүүд нь рациональ бөгөөд ирээдүйгээ бүтээлчээр , зорилго чиглэлтэйгээр төлөвлөж чадсан хатуу загвараар зохиогдсон байвал хатуу үнийн урьдчилсан нөхцлийн тухай кейнсийн сургаалийг хүлээн авахад бэлэн байгаа ажээ. Энэ өөрчлөлтийн улмаас ерөнхий тэнцвэрийн динамикийн онол гэсэн нэр томъёо үүсэв. 1970-1980 оны үед шинэ сонгодог онолчдын гол зорилго нь кейнсийн хуучин макро эдийн засгийн онолоос инженерийн бас шинжлэх ухааны үүднээс татгалзах явдал байлаа. Хэдийгээр Саржент, Лукас хоёр кейнсийн онолыг инженерийн өдөр тутмын ердийн мэдлэг дээр тулгуурласан гэж үзэж байсан боловч Вашингтонд бэлэн авч очих өөрсдийн загвар 1979 он гэхэд шинэ сонгодогчуудад байхгүй болохоо мэдэж байлаа. Дашрамд өгүүлэхэд тэд өөрсдийн санал бодлыг хуваалцахын хувьд ч тэр, түүнийг хэрэгжүүлэхийн тухайд ч нэг их даруухан загнадаггүй байв. “Кейнсийн эдийн засгийн онолын мөхөл “ гэж нэрлэсэн 1980 оны нэгэн өгүүллэгт Лукас “ өөрийгөө кейнсч гэж нэрлэх сайн эдийн засагчдыг олох боломжгүй боллоо. Кейнсийн онолын сургаалийг шинжлэх ухааны семинар дээр хүлээн авахаа больсон нь танхим тэр чигээрээ шивнэлдэн шоолон мушийх байдлаас харж болно” гэж эрс өгүүлжээ. Гэвч Лукасын үүнийг бичиж байх үед кейнсийн шинэ халаа үе эдийн засгийн шинжлэх ухаанд хэдийнээ гараад ирчихсэн байлаа.

Шинэ кейнсчүүд

Орчин үеийн бүх эдийн засагчид ямар нэг хэмжээгээр сонгодог онол баримталсан сургуулиас үүдэлтэй. Бид бүгдээр зах зээлийн үр ашиг, тэнцвэр, сайн сайхан хөгжлийн тухай лекц уншдаг. Шинжлэх ухааны дэг журам баримтлан үүссэн цагаасаа макро эдийн засгийн гол зорилго нь Смит, Маршаллын онол ба Кейнсийн хангалтгүй гэж үзсэн нийт эрэлт бүхий эдийн засгийн шинжилгээ гэсэн хоёр ойлголтыг нэгтгэн зохицуулах явдал байв. Анхны кейнсчүүд / Самуэльсон, Модильяни, Тобин нар / энэ хоёр ойлголт “шинэ сонгодог- кейнсийн синтез” хэмээх хүрээнд нэгдлээ гэж бодож байжээ. Тэд Смит , Маршаллын сонгодог онол нь урт хугацаанд тохирох бөгөөд Кейнсийн богино хугацаанд үл үзэгдэх гарын онол нь зогсонги байдалд орно гэж үзэж байв. Энэ нь үнэхээр цаг хугацааны явцад зарим үнэ, ялангуяа ажиллах хүчний үнэ маш бага өөрчлөгдсөн байдгаар харагдана . Тэд сонгодог загвараар эдийн засаг алгуур хөгжих үеийн тэнцвэрийг төсөөлж байсан , харин кейнсийн загвар нь үнэ мэдэгдэж байгаа тохиолдолд эдийн засгийг тухайн агшинд нь илүү оновчтой тодорхойлж болно гэж нотолж байв. Энэхүү “шинэ сонгодог-кейнсийн синтез” –ийн логик нь зөв боловч уг санаа бүрэн биш учраас цаашид хөгжиж чадаагүй байна. Кейнсийн онолыг баримтлагчид багагүй хугацааны турш ажил хэрэгч мөчлөгийн микро үндэслэлд сэтгэл дундуур байжээ. 1946 онд “макро эдийн засаг “ гэдэг нэр томъёог анх хэрэглэж эхлэхдээ Клейн энэ тухай бичиж байлаа.

Тэр үед шинэ сонгодогчууд синтезээс татгалзан бүхнийг дахин шинээр эхэлсэн бөгөөд шинэ кейнсчүүд тэрхүү онолд хадгалж үлдвэл зохих олон зүйл байгаа гэж үзэж байв. Тэд анхны кейнсчүүдийн нээсэн түвэгтэй зохицолгоо бүхий тогтолцоо загварт гүн гүнзгий шинжилгээ хийхийн тулд микро эдийн засгийн арга хэрэгслүүдийг ашиглахыг эрмэлзэж байв. “Шинэ сонгодог- шинэ кейнсийн синтез” ийг 1940 оод оны үед барьсан байшинтай зүйрлэж болох юм: шинэ сонгодогчууд түүний хуучирсан бүтэц хэлбэрийг хараад удахгүй нуран унана гэж байхад шинэ кейнсчүүд хуучин мастеруудын бүтээлийг гайхан шагшиж нийтээр нь өөрчлөх , их засвар хийх боломжтой гэж итгэж байв. -

Шинэ кейнсчүүдийн судалгаа шинжилгээний эхний үе шат ерөнхий тэнцвэргүйдлийн тухай өгүүлсэн бүтээлүүд байв. Уг бүтээлүүдэд зах зээлд цэвэрлэгээ хийгдээгүй тохиолдолд нөөцийн хуваарилалтыг ойлгохын тулд ерөнхий тэнцвэрийн онолын арга хэрэгслийг ашигласан байна. Энд цалин ба үнийг цаанаас өгөгдсөн / зохицуулсан / гэж үзсэн байна. Нэг зах зээлийн тэнцвэргүй байдал нөгөө зах зээлд хэрхэн нөлөөлж байгааг эдийн засагчид анхааран судалжээ . Энэ онолоор аль зах зээл дээр нийлүүлэлт илүүдэлтэй байна, аль зах зээл дээр эрэлт илүүдэлтэй байна гэдгээс хамааран эдийн засаг янз бүрийн загварууд оршиж болно гэж үзсэн байна. Хамгийн сонирхолтой нь эдийн засгийн уналт ажиглагдаж байгаа үед хамаарагдах –кейнсийн загвар бөгөөд энд таваарын зах зээл , хөдөлмөрийн зах зээл дээр нийлүүлэлт илүүдэлтэй байдаг. Кейнсийн загварын үед ажилгүйдэл бий болдог. Ажиллах хүчний эрэлт бага байгаагийн шалтгаан нь пүүсүүд хүссэн хэмжээний бүтээгдэхүүнээ тухайн үеийн үнээр худалдаж чадахгүй , олонх хэрэглэгч ажилгүй учраас бараа бүтээгдэхүүний

эрэлт ч буурдаг явдал юм. Эдийн засгийн уналт хийгээд зогсонги байдал нь эрэлт хангалтгүйгээс болдог ба түүнийг идэвхжүүлэхэд үржүүлэгчийн нөлөө чухал үүрэгтэй гэж үзсэн. Шинэ кейнсын онолын гол онцлог нь үнийг тогтворжуулах урьдчилсан нөхцөл бүрдээгүй тохиолдолд рационал хүлээлтийг ашиглахад чиглэгдсэн судалгааг олноор хийж байв. Эдгээр судалгаа нь мөнгөний бодлогын ашиггүй болох тухай Саржент, Уоллесын дүгнэлтийн эсрэг үзэл санаа агуулсан байлаа. Мөнгө -санхүү -зээлийн системтэй бодлогын тусламжтайгаар рациональ хүлээлтийг харгалзахгүйгээр эдийн засгийг тогтворжуулж болно гэдгийг дээрх судалгаанууд харуулав. Ер нь судалгаа хайгуулын ажил нь зарим талаараа инфляцийн хэлбэлзлийн бодит загварыг боловсруулах зорилготой уялдсан байлаа. Энэ төслийн эмзэг цэг буюу гол дутагдал нь микро эдийн засгийн зарчимд хүчээр тулгуурласан, практикаас үүдэлтэй хөдөлмөрийн гэрээний хэлбэрийг урьдчилан зааж оруулсан явдал юм. Кейнсийн уламжлалт загвар нь цалин ба үнэ зах зээлийг тэнцвэржүүлдэггүй гэж үздэг бол шинэ кейнсчүүд уламжлалт кейнсийн загварыг дахин тайлбарлахаар зорилоо. Ингээд олон янзын таамаглал дэвшүүлэн судлав: Өөрийн бүтээгдэхүүний үнийг өөрчлөхийн тулд пүүсүүд “цэсийн зардалтай” тулгардаг. Ажилчны хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхийн тулд пүүс өөрийн ажилчдад зах зээлийн тэнцвэрээс дээгүүр цалин төлдөг: цалин ба үнийг тогтоож байгаа субъектүүд рациональ биш ажээ. Мэнькью тэрчлэн Акерлоф ба Йеллен нар тэмдэглэхдээ пүүсүүдэд зах зээлийн ноёрхол байгаа үед хатуу үнэ тогтоох үеийн тэнцвэр нь рациональ буюу бараг рациональ байна. Харин энэ нь нийгэмд хямрал бий болгоно гэжээ. Бланшар, Киотаки нар хувийн болон нийгмийн сонирхлын ялгаатай байгаагийн шалтгаан нь нийт эрэлтийн гадаад нөлөөлөл юм гэдгийг харуулжээ. Хэрэв нэг пүүс үнээ бууруулбал мөнгөн баланс нэмэгдэх бөгөөд ингэснээр бүх пүүсийн бүтээгдэхүүний эрэлт өснө. Болл, Ромер нар пүүсүүдийн аль нэг нь харьцангуй үнийг өөрчлөх оролдлого хийвэл нэрлэсэн үнэ инерцээр чангарах учраас бодит ба нэрлэсэн хатуу үнийн хооронд тогтворыг барьж байх тэнцвэр оршин байдаг гэж тогтоожээ.

Түүхийн хуудас сөхвөл энэ бүх шинэлэг санаа нь тэдгээр эрдэмтдийн тухайн үед бодож байснаас ч илүүтэйгээр хоорондоо олон хэлбэрээр харилцан хамааралтай байсан гэж хэлж болох юм. Жишээлбэл үнэ өгөгдсөн гэсэн хуурмаг урьдчилсан нөхцөл дээр үндэслэсэн зах зээлийн тэнцвэр байнга алдагдаж байх тухай судалгааны программ эхнээсээ л дампуурсан ажээ. Эдгээр судалгааны ажлын үр дүн өнөөдөр заавал судлах жагсаалтанд цөөхөн орсон байх хэдий ч үнэ түргэн зуур өөрчлөгдөж чадахгүй тохиолдолд эдийн засгийн өөрчлөлтийг тайлбарлахад уг санааг ашигласан байдаг.

Шинэ кейнсийн хэд хэдэн үеийн эдийн засагчид пүүсүүд зах зээл дээр ноёрхлоо тогтоосон үедээ ахиу зардлаас дээгүүр үнээр бүтээгдэхүүний үнэ тогтоох зарчмаар тухайн үеийн үнээр улам их бүтээгдэхүүн борлуулахыг хүсч байдаг гэжээ. Хэрвээ пүүс тодорхой хэмжээнд зах зээлийн ноёрхолтой л байгаа бол таваарын зах зээл байнга илүүдэл нийлүүлэлттэй байна. Таваарын зах зээлийн энэ онол нь цалин зах зээлийн тэнцвэрээс ямагт дээгүүр тогтоогдох ёстой гэсэн хөдөлмөрийн зах зээлийн онолтой нийлдэг. Ийм тохиолдолд Кейнсийн илүүдэл

нийлүүлэлтийн загвар боломжтой төдийгүй зах зээлийг хөгжүүлэх үндсэн арга замуудын нэг болж байгаа юм.

Шинэ Кейнсийн онолын үр дүн нь богино хугацаанд макро түвшинд далд гарын онол үйлчлэхгүй гэсэн үзэл санаан дээр үндэслэсэн, дэс дараалал бүхий эдийн засгийн онол байлаа. Хатуу үнийн нөхцөлд зах зээлүүдийн харилцан хамаарал, үнийг өөрчлөх шийдвэрийг хэн гаргаж байгаа, урамшуулал болон хүлээлт ямар үүрэгтэй байхыг бид ойлгож байна. Хэдийгээр шинэ кейнсчүүд хувьсгалчид байгаагүй боловч өөр бусад нь хийхийг эрмэлзээгүй, хийж чадаагүй байсан судалгааг хийсэн нь шинжлэх ухаанд амжилт гаргаж чадсан юм. Ерөнхийдээ тэд хувьсгалын эсрэг үзэлтнүүд байсан гэх учир нь: тэдний зорилго бол шинэ сонгодог-кейнсийн синтезийн үзэл санааг сонгодог онолын шинэ төлөөлөгчдийн халдлагаас хамгаалах явдал байв. Эдгээр судалгаа нь шинжлэх ухаанд нааштай байсны нэгэн адил инженерийн чанарын хувьд ахиц байв уу? Ажил хэрэгч судалгаа хийж, бодлого боловсруулдаг улс төрчдөд тус болж чадсан уу? Энэ асуултуудад эерэг хариу, дүгнэлт өгч хараахан чадахгүй юм.

Гэхдээ шинэ кейнсчүүд нь сонгодог онолчдыг бодоход илүү ихээр инженер болохыг хүсч байсан. Миний мэдэхээс шинэ сонгодог онолчдоос нэг ч эрдэмтэн шинжлэх ухааны судалгааг орхин улс төрч болохыг хүсч байгаагүй. Харин шинэ кейнсчүүдээс олон хүн их сургуулиа орхин төрийн албанд ажиллаж байсан уламжлал бий. Жишээлбэл: С.Фишер, Л.Саммерс, Ж.Стиглиц, Ж.Йеллен, Ж.Тейлор, Р.Клариде, Б.Бернанке бас миний бие орно. Эхний дөрвөн эрдэмтэн Клинтонь засгийн газрын үед, дараагийн дөрөв нь Бушийн ерөнхийлөгч байх үед Вашингтонд ажиллаж байв.

Эдийн засагчдын мэтгэлцээн ба егөөдөл

1990 оны эхээр макро эдийн засгийн судалгаа шинжилгээний гол зорилго нь эдийн засгийн өсөлтөнд үнэлгээ өгөх явдал байв. Нэгдүгээрт эдийн засгийн онолын хамгийн түвэгтэй асуудал болох баян, ядуу орнуудын хоорондын хэтэрхий том ялгаанд шинжилгээ хийх арга хэрэгсэлийг хайх, шинэ санаа дэвшүүлэх явдал байсан бөгөөд энэ нь П.Ромер болон бусад судлаачдын бүтээлд тусгагджээ. Хоёрдугаарт бусад орнуудын талаарх тоо баримт олдоцтой болж шинээр дэвшүүлсэн онолыг шалгах боломж нэмэгдсэн байна. Гуравдугаарт 1990-ээд онуудад АНУ-ын эдийн засаг өөрийн түүхэнд өсөлтийн хамгийн дээд шатанд хүрсэн явдал байлаа. Анхны кейнсчүүд эдийн засагчид нийгмийн баялгийг нэмэгдүүлэхэд нөлөөлж чадна гэсэн үзэлтэй байсан бол 1990-ээд оны оюутнууд ажил хэрэгч мөчлөгийн онол нь практикт чухал ач холбогдолгүй юм гэсэн үзлээр хүмүүжжээ.

Түүнчлэн дөрөвдэх илүү чухал нэгэн шалтгаан нь 1990-ээд оны итгэл төрүүлсэн эдийн засаг нь эдийн засагчдад богино хугацааны флугтац бус харин урт хугацааны өсөлтийг судлахад гол анхаарал тавихад хүргэсэн явдал юм. Энэ нь шинэ сонгодог ба шинэ кейнсчүүдийн хоорондын нөгөө л үзэл бодлын зөрчилдөөний үндэс оршсоор байгааг харуулж байлаа. 1980 онд ерөнхийлэгчээс америкийн эдийн засгийн холбоонд явуулсан илгээлтэнд шинэ сонгодог онолчид “ямар нэг урьдчилсан нөхцлөөс үүдэн тогтоосон хатуу үнэ, цалин хөлсөөр зах

зээл тэнцвэржих боломжгүй учраас судалгаанаас хасах” гэсэн хүсэлтийг Солоу “тэнэг хязгаарлалт” гэж нэрлэв. Энэ тухай Солоу “анааш өөрийн толгойдоо хангалттай хэрэглэх цусыг хэрхэн яаж шахаж чадаж байгаа нь одоо хүртэл тодорхойгүй гэхдээ үүнээс үүдэн анааш урт хүзүүгүй гэсэн дүгнэлт хэн нэгэн гаргах уу “ гэж тоглон хэлсэн байдаг. Тухайн сэдвээр хэдэн жилийн дараа ярилцлага өгч байхдаа Кламер, Лукас хоёр Солоу тоглоом шоглоомоо орхиод дээрх асуудлуудын аль нэгийг судална гэдэг юу л бол гэж тэмдэглэсэн байдаг. Тэгтэл Солоу нэгэн ярилцлагадаа шинэ сонгодог онолчидтой хамтран ажиллах хүсэлгүй байгаагаа ингэж тайлбарласан байдаг. ” Хэн нэгэн этгээд таны хажууд ирж суугаад өөрийгөө Наполеон Бонапарт гэж хэллээ гэж төсөөлөн бодлоо. Тэгээд ч зогсохгүй Аустерлицын тулалдаанд орсон морин цэргийн тактикийн талаар цэргийн техникийн урлагийн маргаан өрнүүлэн таныг шахамдуулж эхэлнэ. Тэгтэл та түүний арганд аяндаа автагдан энэ хүн үнэхээр Наполеон мөн байна гэж бодох болно ” гэжээ. Лукас болохоор Солоу шинэ сонгодог онолчдын дэвшүүлж байгаа аналитик хатуу мөрдлөгүүдийг үнэлэхгүй байна гэж шүүмжлэв. Харин Солоу зах зээлийг тэнцвэржүүлэх талаар гаргасан эрүүл саруул үнэлгээг хүлээн авч чадахгүй байгаад нь гомдоллов. Эдгээрийн аль аль талд өөрийн гэсэн нугарашгүй үзэл бодол байгаа нь тодорхой юм. Шинэ сонгодог онолчдын дэвшүүлсэн шинжлэх ухаанч мөрдлөг үнэхээр анхаарал татахуйц чухал билээ. Харин түүнийг инженерийн нүдээр харвал нэмэлт ихтэй хатуу мөрдлөг нь хэтэрхий үнэ цэнэтэй байх ажээ.

Энэ халз маргааныг ийнхүү тодорхой дурьдсан нь инженер эрдэмтэн хоёрын хоорондох зөрчлийг харуулахын үүднээс бус харин дараагийн залуу эдийн засагч нарт сонголт хийхэд туслах зорилготой юм. Сэтгэл нь хөөрсөн том сэхээтнүүдийн маргаан нь олон нийтийн анхаарлыг татах боловч макро эдийн засагт ашиг тусаар бага юм. Олон залуу эдийн засагч энэ маргаанд аль нэгний талд орохоос зугтан эдийн засгийн бусад сэдвээр ярихийг илүүд үздэгт гайхах юм алга.

Шинэ синтез үү эсвэл эвлэрэл үү?

Эртний цэцэн үгэнд шинжлэх ухаан оршуулгаас оршуулга хүртэл хөгжил л байдаг гэсэн ажээ. Хүний амьдрах дундаж нас урт болж буй өнөө үед шинжлэх ухаан тэтгэвэрээс тэтгэвэр хүртэл хөгжсөөр байна гэх юмуу даа. Ахмад үе тэтгэвэрт гарах үед тэдний халааг залуу мэргэжилтнүүд авч байна. Ингэж эдийн засгийн флуктацыг ойлгох илүү тохиромжтой зам болох шинэ концепци үүссэн ажээ. Гудфренд, Кинг нар энэ үзлийг шинэ бөгөөд шинэ сонгодог синтез гэж нэрлэв. Тухайн шинэ загварыг мөнгөний бодлогын судалгаанд авч ашигласан байдаг. Энэхүү шинэ сонгодог синтезийн үзэл санааг Вудфорд өөрийн нэгэн сэдэвт бүтээлд дэлгэрэнгүй тайлбарласан. Өмнөх үеийн шинэ сонгодог-шинэ кейнсийн синтезийн адил шинэ синтезийн хүрээнд хоорондоо өрсөлдөн байгаа аргуудын давуу талыг нэгтгэхийг эрмэлзэж байв. Энэ синтезэд шинэ сонгодог онолчдоос стохастик ерөнхий тэнцвэрийн динамик онолын арга хэрэгслийг авч ашигласан байна. Судалгааг оптиматжуулалт болон хязгаарлалтыг илүүд авч үзсэн микро эдийн засгийн сууринаас үндэслэжээ. Богино хугацааны мөнгөний бодлогын бодит нөлөөллийн шалтгааныг тайлбарлахын тулд кейнсийн онолын

хатуу үнийн зарчмыг ашигласан байна. Нийтээр хүлээн зөвшөөрсөн арга нь-монопольт өрсөлдөөний нөхцөлд пүүсийн үнэ өөрчлөгдөх бөгөөд тэдгээрийн үнийн динамикийг шинэ кейнсийн Филлипсийн муруй гэж заримдаа нэрлэж байдаг аргыг хэрэглэж болно гэсэн санаа дэвшүүлжээ. Энэхүү синтезийн гол санаа нь : эдийн засгийг Парето оптимумаас ялгаатай, хатуу үнийн хүчээр тогтоосон динамик тэнцвэрийн систем гэж үзсэн явдал юм.

Энэ үзэл санааг агуу ололт гэж үзмээр байна. Тийм ч байж болох юм. Нөгөөтэйгээр тухайн үзэл санааг дэмжихгүй байж ч болох талтай. Ерөөсөө энэ нь үзэл бодлын синтез биш өрсөлдөгч талууд арьсаа хамгаалан аль нь ухралт хийсэн байж магадгүй юм. Шинэ сонгодогчууд, шинэ кейнсчүүд бий болсон хүнд байдлыг зайлуулж чадаад өөр өөрийн ялалтанд сэтгэл хангалуун үлдэв.

Энэ шинэ синтезийн үндсийг анхны кейнсчүүдийн загвараас харж болно. Жишээлбэл Хикс IS-LM загварыг гаргаж тавихдаа Кейнсийн ерөнхий тэнцвэрийн үзэл санааг загвартаа шингээхийг оролдож байв. / 1972 онд К.Эрроу Хикс нарт энэ онолд оруулсан хувь нэмрийг үнэлж Нобелийн шагнал хүртээсэн юм./ Клейн, Модильяни нар тоон үзүүлэлттэй ерөнхий тэнцвэрийн системийг илүү сайн эдийн засгийн бодлогыг боловсруулахын тулд ашиглахыг оролдож байв.

Өнөөдөр шинэ сонгодогчууд өөрсдийн өгч чадахаас илүүг амлаж байсан нь харагдах болжээ. Тэд хэрвээ кейнсийн онолыг зах зээлийн тэнцвэрийн загвараар сольж чадвал, тоон үзүүлэлтийн үндсэн дээр эдийн засгийн бодлогын шинжилгээнд ашиглаж болно гэж үзэж байлаа. Гэвч тэдний энэ оролдлого амжилтгүй боллоо. Хэдий тийм боловч тэд шинэ халаа үеийнхэндээ урьдчилсан нөхцөлт хатуу үнийн зарчмыг ашиглан загвар боловсруулах аргачлалыг бий болгож өгсөн байна.

Шинэ синтезийн хүрээнд эдийн засагчид зах зээлийн тэнцвэржилтийн тухай хэлэлцэхээс татгалзаж ингэснээр хатуу үнийн тухай шинэ кейнсийн сургаалийг няцаахыг эрмэлзэх болов. Тэгэхээр шинэ кейнсчүүд шинэ сонгодогчуудын тавьсан занганд орсон байж таарлаа, ингэснээр /үүний үр дүнд / амьдрал практикт төдийлэн хэрэгжихгүй хэтэрхий хийсвэр судалгааны программыг барих болжээ. Жишээлбэл П.Кругман хатуу үнэ хэрхэн үүсэж байгааг одоо хялбархан тайлбарлаж болно гэж өгүүлэв. Үнэндээ хатуу үнэ яаж бий болж байгаа тухай итгэл үнэмшилтэй тайлбар, загвар байхгүй бөгөөд цэсийн зардлаас Филлипсийн муруй дээр туршилтаар боловсруулсан шилжилтийг харуулахаас өөр бодитой загвар, нотолгоо байхгүй байна. Шинэ кейнсчүүдийн талыг баримтлагч би Кругманы энэ дүгнэлтэнд үнэний хувь байгаа гэж хүлээх ёстой болж байна.

Фискаль бодлогын үүднээс харахуй

Макро эдийн засгийн онолд практик нөлөө харилцан үзүүлж байдаг салбар бол-татварын бодлого тул түүнд хийсэн дүн шинжилгээг авч үзье.

Ж.Бушийн засгийн эрх барьж байсан 2001 - 2003 онд татварыг бууруулсан сайхан жишээг дурьдаж болох юм. Эдийн засгийн хорооны даргын зөвлөхийн албан тушаалд хоёр жил ажиллахдаа миний бие дээрх бодлогын үндэслэл болсон

ихээхэн хэмжээний баримтыг задлан шинжлэхэд оролцсон билээ. Бушийн энэ фискаль бодлогын төсөл хэрэгжихээс өмнө эдийн засаг – нийгэм, улс төрийн урьдчилсан таатай нөхцөл байсан нь тодорхой юм. Харин фискаль бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэхэд Эдийн засгийн хорооны зөвлөхүүдийн шинжээч нар, Татварын ерөнхий газар ихээхэн хувь нэмэр оруулсан билээ. Бушийн татварын шинэчлэлийн эдийн засгийн дүн шинжилгээг удаан хугацааны өсөлтийг харгалзсан богино хугацааны ажил эрхлэлийн мөчлөг дээр үндэслэн хийсэн юм. Урт хугацааны хөгжлийн хэтийн төлөв нь мэдээж нийгмийн секторын эдийн засагт чиглэсэн байх ёстой байв. 2003 онд Буш корпорацийн капиталын орлогын давхар татварыг болиулах санал дэвшүүлэв. Хэдийгээр хуулийн төслийн эцсийн хувилбарыг Конгресс хүлээн авсан боловч зорилго нь бүрэн гүйцэд биелж чадаагүй юм. Ер нь ноогдол ашгийн татварыг ийнхүү бууруулах нь татварыг нийтээр бууруулах хандлагыг бий болгосон. Татварын хуулийг - орлогын талд биш хэрэглэгээний татвар ноогдуулалтын талд ашигтайгаар өөрчлөв. Энэ нь нийтийн санхүүжилтэнд хэрэглэдэг бүхний мэдэх арга учраас эдийн засгийн онолд шинэ зүйл биш байлаа. Бүр 30 –аад жилийн өмнө ийм аргыг хэрэглэж болохыг Аткинсон, Ж.Стиглиц нар тэмдэглэж байжээ. Харин богино хугацааны фискаль бодлого манай өгүүллэгийн сэдэвт илүү ойрхон юм. Бушийн ерөнхийлэгч болсон 2001 онд 1990-ээд орны төгсгөлд хэрэгжүүлж байсан хөрөнгийн зах зээлийн бодлого савангийн хөөс шиг хагарсан юм. Татварыг бууруулах зорилго нь эдийн засгийг идэвхжүүлэх, ажилгүйдэлтэй хийх тэмцэл явдал байв.

“2003 онд татварыг бууруулах, ажлын байрны тоог нэмэгдүүлэх тухай акт” -ыг Буш тайлбарлахдаа хэрвээ хүмүүс хувьдаа их мөнгөтэй бол түүнийгээ бараа таваар үйлчилгээ худалдан авахад зарцуулах болно. Манай нийгмийн хүмүүст нэмэлт бараа таваар, үйлчилгээ эрэлт хэрэгцээтэй байвал хэн нэгэн тэдгээрийг үйлдвэрлэх нь дамжиггүй. Тэгээд хэн нэг нь таваар, үйлчилгээг үйлдвэрлэж эхэлмэгц нөгөө хэсэгт нь ажил олоход хялбар байх болно. Энэ логик нь Кейнсийн онолын үндэс байв.

Эдийн засгийн хорооны зөвлөгч нарт татварын хөнгөлөлт нь ажил эрхлэхэд яаж нөлөөлж байгааг тодорхойлох хүсэлт тавилаа. Энэ асуултанд бид мейнстримийн каноноор боловсруулсан макро эдийн засгийн загвараар хариу өгсөн билээ. Түүхийн хувьд энэ загвар нь Кейнс, Модильян, Экштейны анхны загваруудын нэг байв. Энэ загварт шинэ сонгодог -онолчид ба шинэ кейнсчүүдийн судалгаа шинжилгээний нөлөө маш бага байсан юм. Амьдралын энэ бодит байдалтай танилцсанаар макро эдийн засаг -улс төрийн төлөвлөлт хийж байдаг, ихэнх цагаа шинжлэх ухааны танин мэдэхүйд зориулсан хүмүүс бол сэтгэлээр гутарч болохоор байв. Үнэндээ макро эдийн засгийн сүүлийн 30 –аад жилийн судалгаа шинжилгээ нь фискаль ба мөнгөний бодлогын практик дүн шинжилгээнд нь маш өчүүхэн нөлөө үзүүлсэнд үнэхээр харамсаар байдаг. Улс төрийн үйл ажиллагаанд оролдож байдаг эдийн засагчид шинжлэх ухааны сүүлийн ололтыг мэдэхгүй байгаагаар үүнийг тайлбарлаж болох юм. Гэвч байдал сайжрах төлөвтэй нь: Холбооны Төв Банкны –албан тушаалд шинжлэх ухааны шилдэг залуу докторууд томилогдон очиж, Эдийн засгийн хорооны

зөвлөхийн албан тушаалыг бүрдүүлэхдээ гарамгай сайн судлагаа хийдэг их сургуулиас авьяаслаг залуу мэргэжилтнүүдийг авч байна. Харин орчин үеийн макро эдийн засгийн судлагаа, шинжилгээг бодит бодлого төлөвлөхдөө хангалтгүй ашиглаж байгаа хийгээд практик ашиг багатай нь бодит баримт мөн. Эдийн засгийн шинжлэх ухаанд үнэхээр ач холбогдолтой боловч макро эдийн засгийн инженерийн хувьд оруулсан ахиц нэмэр төдий л их бус байгаа юм.

✓ Танхимаас илгээсэн харц

Дэлхийн капиталын засаглалын том хонгилын зэрэгцээ эдийн засагчид өөрийн капиталыг худалдахыг оролдож байдаг бас нэгэн булан байдаг нь: оюутны танхим билээ. Багшийн ажил байнга хийж байдаг бидний ажлын зорилго – зөв бодлого боловсруулах зарчмын тухай сайтар ойлгож гэгээрсэн мэргэжилтнийг их сургууль төгсгөх явдал гэж тооцоолж байдаг юм. Тиймээс заах материалын сонголт нь шинэ элсэгчийг зөв ойлгохоос эхэлнэ. Улс төрчдийн адил оюутнууд онолыг судлахаар олигтой хичээх дургүй байдаг юм. Тэдэнд бодит амьдралын зүй тогтол болон төрийн бодлогоор дамжуулан эдийн засгийн үр ашгийг яаж дээшлүүлэхийг ойлгуулах нь илүү сонирхолтой байдаг. Ахлах курсийн оюутан ихэнх тохиолдолд эрдэмтэн биш харин инженер болох хүсэлтэй байдаг. Ийм учраас бид тэдэнд чиглүүлэн зааж сургах нь чухал билээ. Тэгэхдээ хэрэглэж байгаа сурах бичгээр нь үүнийг тодорхойлох илүү хялбархан юм аа.

Жишээлбэл: дунд түвшний макро эдийн засгийн сурах бичгийг авч үзье. Өнгөрсөн үеийнхэнд уг курсийг судлахад гурван гол ном, сурах бичиг байсан нь: Гордон, Холл хоёрын ба Тейлор, Дорнбуш, Абелем нарын болон, Фишерийн бүтээл байв. Өнөөдрийн хэрэглэж байгаа гол сурах бичиг нь Бланшар, Абелем хоёр хийгээд Бернанке болон таны дуулгаварт зарцын ном билээ. Эдгээр зургаан номыг зохиогч нар Самуэльсон, Солоу нарын макро эдийн засгийн уламжлал ноёрхсон илэрхий “инженер”-ийн сургууль болох Массачусетсын их сургуулийн төгссөн гэх нэгэн цэг дээр нийлдэг билээ. Энэ сурах бичгүүдийн онолын үндэс нь – эрэлт, нийлүүлэлтийн үзэл санаа чухамдаа IS-IM загвар дээр үндэслэсэн улмаар нийт эрэлтийн онол дээр тулгуурласан байдаг. Тэрчлэн уг сурах бичгээс анхан шатны эдийн засгийг: бага хэмжээний эдийн засгийн хэлбэлзлийг авч үзэхдээ ихэнхдээ нэн шинэ сонгодог онол-кейнсийн синтезийн ямар нэг хэлбэрийг ашигласан болохыг олж харж болно.

Шинжлэх ухаан хөгжиж байх зуур сурган хүмүүжүүлэх ухаан байрандаа зогсож байна гэж хэлэхийг хүсээгүй юм шүү. Өнөөдрийн сурах бичигт мөнгөний сонгодог онолын загвар болон хүлээлтийн үүргийн талаар бичсэн нь 30 жилийн өмнөхөөс хавьгүй их зай эзэлдэг болжээ. Эмх цэгцтэй улс төр-эдийн засгийн бодлого байх боломжтой тухай урьдын итгэл үнэмшил аль хэдийн алга болж, хэсэгчилсэн альтернатив дүрэм журмыг зайлшгүй мөрдөх тухайд онцгойлон сануулсан мөнгө санхүүгийн ба татварын бодлогыг илүү анхаарах болжээ. Харин оюутнуудад заадаг ажил хэрэгч мөчлөгийн шинжилгээ нь кейнсийн анхны үеийн танил болсон тэр хүрэн дотроо байсаар байна.

Үүнийг халсан ном бол 1984 онд анх хэвлэгдсэн Бэрроугийн сурах бичиг юм. Энэ ном макро эдийн засагт шинэ сонгодог онолыг яаж хэрэглэхийг энгийн тодорхой өгүүлсэн байдаг. Сурах бичигт хамгийн сүүлд нь кейнсийн загварын тухай маш товчхон оруулсан байна. Ном нийтлэгдэн гарангуут ихээхэн нэр хүндийг олов. Хэдий тийм боловч бүх багш нар өөрийн оюутнуудад уншихийг зөвлөөгүй юм. Бэрроугийн найдсан шиг цоо шинэ сонгодог онолын хувьсгал сурган хүмүүжүүлэх салбарт болоогүй бөгөөд тэр үеийнхээ сурах бичгүүдтэй хүчтэй өрсөлдөгч байж чадсангүй.

Энэ нь макро эдийн засгийн сурган хүмүүжүүлэх ухаанд хагас зуун жилийн өмнөх шиг хувьсгалт үзэл санаа байхгүй байгааг харуулж байна. Тэртээ 1948 онд Самуэльсоны сурах бичиг анх хэвлэгдэн орж ирээд л оюутнуудад кейнсийн хувьсгалт үзэл санааг дэлгэхэд дэлхийн бүх багш нар энэ шинэ аргыг бахархалтай шүүрэн авсан билээ. Харин шинэ сонгодог ба шинэ кейнсийн үзэл санаа өнөөдрийн макро-эдийн засгийн заах аргыг төдийлэн их өөрчлөж чадахгүй байна.

Яагаад ч юм шүдний эмч шиг харагдахгүй байна

Кейнсийн нэгэн алдартай ишлэлд эдийн засагч нар маань хүмүүст өөрийгөө даруухан, найрсаг мэргэжилтэн тухайлбал шүдний эмч нар шигээр ойлгож хүлээж авдаг болговол гайхамшигтай яа гэж билээ. Тэрээр макро эдийн засаг нь ямагт ашиг тустай, инженер шиг сэтгэл татсан хэлбэртэй болоосой гэж найдаж байв. Энэхүү хоосон санаашралд хямралыг шийдэх нь шүдэнд ломбо тавихтай адил амархан байх гэсэн хүсэл мөрөөдөл шингэсэн нь лавтай. Сүүлийн арван жилд макро эдийн засгийн шинжлэх ухааны гол ололт нь шүдний эмнэлэг шиг хүмүүст ач тустай байж төдийлэн чадсангүй. Шинэ сонгодог онолчид, шинэ кейнсчүүдийн нэр их судалгаа шинжилгээ нь, ямагт сайн нэртэй байдаггүй фискаль ба мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч, практик-макро эдийн засагч нарт бараг нөлөөлсөнгүй. Хичээлийн танхимд ирээдүйн эдийн засагч нарт босго алхангуут макро эдийн засгийн бодлого ярьдаг багш нарын байдал ч бараг өөрчлөгдсөнгүй. Инженерийн ажил төрлийн талаас харвал сүүлийн арван жил бүхэлдээ урагшгүй байлаа.

Харин онолын зүгээс ямар ч байсан эдгээр ажлыг нь эерэг сайнаар үнэлж болно. Шинэ сонгодогчууд *төрийн заавар зохицуулалт дээр үндэслэсэн нийтэд түгсэн кейнсийн загварууд хязгаарлагдмал болохыг харууллаа*. Тэд төрийн зохицуулалтын практикт хүлээлт чухал болох тухайд олны анхаарлыг хандуулж чадлаа. Шинэ кейнсчүүд *цалин хөлс болон үнэ яагаад зах зээлийг тэнцвэржүүлж чадахгүй байгааг тайлбарлах илүү сайн тохирох загварыг* дэвшүүлэн гаргав. Энэ нь гүнзгий утгаар авч үзвэл богино хугацаанд болдог эдийн засгийн хэлбэлзэлийг ойлгоход зах зээлд ямар нөхцөл дутагдаж байгааг тооцох гэсэн санаа юм. Хоёр сургаал, урсгалын хоорондох зөрчил бие биеэ хүндэтгэсэн соёлтой байж чадаагүй хэдий ч үр бүтээлтэй байсан нь, угаасаа оюун ухааны дэвшил хөгжил бол зах зээлийн жамаар өрсөлдөөн сөргөлдөөнтэй байдагт оршино.

Үүний үр дүнд бий болсон мэдлэг нь өнөөдөр улам цааш хөгжин шинэ синтезэд шингэн, улмаар эцсийн үр дүндээ дараагийн үеийн бүтээх макро

эдийн засгийн загварын үндэс суурийг тавьж өгч байна. Макро эдийн засгийг шинжлэх ухаан гэж байгаа нь ч тэр, инженер гэж байгаа нь ч тэр одоо бий болоод байгаа онолын синтезийг сайны шинж гэж тооцож болох юм аа. Хоёр фронтоор тулалдвал илүү их амжилт гаргана гэдэгт найдаж болно. Сайн макро эдийн засагч мэдлэгтэй байхын зэрэгцээ найрсаг даруу зан чанартай байж ажлаа үргэлжлүүлнэ байх хэмээн би ирээдүйг эерэг сайнаар харж байнам.

Ашигласан ном зүй.

“Вопросы Экономики” сэтгүүлийн 2009 оны 5 дугаараас орчуулав.
Онолын тулгамдсан асуудалд зориулан бичсэн проф Н.Г Мэнкьюгийн
“Макроэдийн засагч бол эрдэмтэн хийгээд инженер мөн” өгүүлэл.